



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 11/237

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын салбарын
2025-2028 оны стратеги төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн даатгалын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Б.Батжаргал)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газар (В.Рэнцэнханд)-т, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Д.Ренчиндорж)-т биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Б.Батжаргал)-т тус тус даалгасугай.



Т.АУБАКИР

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2025 оны 12 дугаар сарын 19-ны
өдрийн 1237 дугаар тушаалын хавсралт



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	1
ХОЁР. АЛСЫН ХАРАА	1
ГУРАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	1
ДӨРӨВ. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	1
ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	20
ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	26
ДОЛОО. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ	27
НАЙМ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН ЗУРАГЛАЛ	31

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/119 дүгээр тушаалаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө баталсантай холбогдуулан Нийгмийн даатгалын салбарын стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Нийгмийн даатгалын салбарын стратеги төлөвлөгөө (цаашид “стратеги төлөвлөгөө” гэх)-г Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны “Аргачлал, заавар батлах тухай” 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг тус тус үндэслэн боловсруулав.

Стратеги төлөвлөгөө нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээнд чиглэх ба нийгмийн даатгалын салбарын хөгжлийн хэтийн хандлага, 2025-2028 он дуусталх хугацаанд баримтлах стратегийн бодлогын зорилт, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг тогтооход оршино.

ХОЁР. АЛСЫН ХАРАА

Нийгмийн даатгалын байгууллага нь 2030 он гэхэд даатгуулагчдын насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болно.

ГУРАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Нийгмийн даатгалын байгууллагын эрхэм зорилго нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлэхэд оршино.

ДӨРӨВ. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд даатгуулагч, ажил олгогчид олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Нийгмийн даатгалын салбарт нийт 72 хууль тогтоомж мөрдөгдөж байгаагаас нийгмийн даатгалын 9 хууль, нийтлэг мөрдөгдөж байгаа 63 хууль байна.

Хүснэгт 1. Салбарын үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн жагсаалт

№	Хуулийн нэр
1.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль
2.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай
3.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай
4.	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай
5.	Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай (жил бүрийн)
6.	Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай
7.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай
8.	Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай
9.	Эрүүл мэндийн даатгалын тухай

Хүснэгт 2. Нийтлэг мөрдөж буй хууль тогтоомжийн жагсаалт

№	Хуулийн нэр
1.	Монгол Улсын Үндсэн хууль
2.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай
3.	Монгол Улсын Прокурорын тухай
4.	Монгол Улсын Шүүхийн тухай
5.	Монгол Улсын Хилийн тухай
6.	Монгол Улсын Хилийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
7.	Авлигын эсрэг хууль
8.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай
9.	Ахмад настны тухай
10.	Гаалийн тухай
11.	Гамшгаас хамгаалах тухай
12.	Гүйцэтгэх ажлын тухай
13.	Гэр бүлийн тухай
14.	Дипломат албаны тухай
15.	Дотоодын цэргийн тухай
16.	Дотоодын цэргийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
17.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай
18.	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай
19.	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
20.	Захиргааны ерөнхий хууль
21.	Зөвшөөрлийн тухай хууль

22.	Зөрчил хянан шийдвэрлэх тухай
23.	Зөрчлийн тухай
24.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай
25.	Иргэний хууль
26.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай
27.	Нийгмийн халамжийн тухай
28.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
29.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай
30.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай
31.	Нягтлан бодох бүртгэлийн тухай
32.	Статистикийн тухай
33.	Тагнуулын байгууллагын тухай
34.	Татварын ерөнхий хууль
35.	Төр, сүм хийдийн харилцааны тухай
36.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай
37.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай
38.	Төрийн албаны тухай
39.	Төрийн аудитын тухай
40.	Төрийн болон албаны нууцын тухай
41.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
42.	Төрийн хэмнэлтийн тухай
43.	Төрийн хяналт шалгалтын тухай
44.	Төсвийн тогтвортой байдлын тухай
45.	Төсвийн тухай
46.	Харьяатын тухай
47.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай
48.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай
49.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай
50.	Хөдөлмөрийн тухай
51.	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай
52.	Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай
53.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай
54.	Хүүхэд хамгааллын тухай

55.	Цагдаагийн албаны тухай
56.	Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
57.	Цахим гарын үсгийн тухай
58.	Цэргийн алба хаагчийн эрхзүйн байдлын тухай
59.	Цэргийн албаны тухай
60.	Шилэн дансны тухай
61.	Шүүх шинжилгээний тухай
62.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай
63.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай

Нийгмийн даатгалын байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний шинжилгээ мандатын шинжилгээг дараах байдлаар хийж гүйцэтгэв:

Хүснэгт 3. Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		72
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	9
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	63
Ерөнхий чиг үүрэг-1: Төрийн захиргаа, удирдлагын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
УЧҮ-1: Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах;	-Нийгмийн даатгалын Төсвийн төвлөрүүлэн захирагч, Төсвийн шууд захирагч, Дотоод нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулах, тайлангийн гүйцэтгэлийг холбогдох байгууллагад хугацаанд нь тайлагнах; -Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурал, нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн болон цаг үеийн шуурхай хурал, цуглааныг зохион байгуулах, гарсан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах; -Тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлийг холбогдох байгууллагад хугацаанд нь тайлагнах; -Нийгмийн даатгалын ерөнхий газрын барилгын ашиглалт болон байрны цахилгаан, дулаан, усан хангамж, холбооны зэрэг үйлчилгээний холбогдох байгууллагуудтай аж ахуйн гэрээ байгуулан төлбөр тооцоог хугацаанд нь хийж тухайн байгууллагатай байгуулсан гэрээг дүгнэж ажил үйлчилгээний чанар, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах;	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Шүүх, Цагдаа, Прокурор болон хууль хяналтын байгууллагууд

	-Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирсэн албан бичиг болон иргэдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, бүртгэн, албан бичгийг шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох мэдээ тайланг хугацаанд нь гаргах; -Салбарын хэмжээнд мөрдөгдөх архив, албан хэрэг хөтлөлтийн арга зүйн баримтыг боловсруулах, байгууллагын архивын үйл ажиллагаа, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, баримт боловсруулах; -Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас ажил олгогч, даатгуулагч, иргэдийн хүсэлтээр шимтгэл төлөлтийн талаарх лавлагааг олгох үйлчилгээ үзүүлэх.	
ҮЧҮ-2: Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийг төлөвлөж, бүрдүүлэлт хийх, чадварлаг төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчдаар агентлагийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах;	-Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах, сайжруулах; -Хүний нөөцийн нийлүүлэлт, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэх, бууруулах асуудлыг шийдвэрлүүлэх; -Төрийн албан хаагчийн ажлын үр дүн, мэргэжлийн түвшний үнэлгээ хийх, төрийн захиргааны зэрэг дэв ахиулах, нэмэгдүүлэх, хасах, хүчингүй болгох санал боловсруулах, шийдвэрлүүлэх; -Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлаар санал боловсруулах, шийдвэрлүүлэх; -Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх, Нийгмийн даатгалын улсын байцаагчийн үнэмлэх тэмдэг олгох, хураах ажлыг холбогдох журмын дагуу хэрэгжүүлэх, зохион байгуулах; -Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан, албан хаагчдыг Төрийн дээд шагнал, одон, медальд нэр дэвшүүлэх, шагнуулах хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; -Нийгмийн даатгалын байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад тусламж, дэмжлэг олгох, хүндэтгэл үзүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах.	
ҮЧҮ-3: Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн	-Нийгмийн даатгалын салбарын ажилтнуудыг сургаж хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах;	

чадавхыг бэхжүүлэх, сургаж хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;	-Салбарын ажилтнуудыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг зохион байгуулах, үнэлгээ хийх; -Сургалтын шинэ арга зүй, технологи нэвтрүүлэх, сургалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх. -Ажил олгогч, даатгуулагч, харилцагч байгууллагын ажилтнуудын нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн цуврал сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтыг зохион байгуулах; -Салбарын хэмжээнд нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох шалгалтын бэлтгэл ажлыг хангах, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчилж баяжуулах, шалгалт зохион байгуулах, дүнг гаргах, холбогдох шийдвэрийг гаргуулах; -Сургалтын платформыг хөгжүүлэх. -Нийгмийн даатгалын улсын байцаагчийн акт, дүгнэлттэй холбоотой маргааныг дахин хянах, холбогдох танилцуулга, дүгнэлт гаргах, маргааныг шийдвэрлэх бэлтгэл ажлыг хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх, Шүүх, өмгөөллийн байгууллагатай хамтран ажиллах; -Нийгмийн даатгалын салбар байгууллага, албан хаагч, байцаагч, ажилтнуудын ёс зүйн зөрчлийн талаар нэгдсэн бүртгэл хөтлөх, нийгмийн даатгалын байцаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, зан харьцаа, авлигатай холбоотой асуудлаар судалгаа хийх, дүгнэх санал боловсруулах; -Нийгмийн даатгалын салбар байгууллагуудад хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах; -Нийгмийн даатгалын албан хаагчдын үйл ажиллагаанд дотоодын хяналт тавьж, хүнд суртал, авлига, ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хууль хяналт, олон нийтийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж соён гэгээрүүлэх сургалт явуулах; -Шүүхийн шийдвэртэй нийгмийн даатгалын өр, авлага барагдуулахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албатай хуулийн хүрээнд хамтран ажиллах.
	Ерөнхий чиг үүрэг-2: Бодлогын хэрэгжилт, төлөвлөлт, судалгааны чиглэлээр

Үндсэн чиг үүрэг: Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Төрөөс нийгмийн даатгалын талаар баримталж байгаа бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, түүний үзэл баримтлалын төсөл, бодлого, хөтөлбөрийн төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	-Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар судалгаа хийх, санал боловсруулах, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх; -Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, дүрэм, заавар, аргачлал боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зөвлөмж боловсруулах, мэргэжил арга зүйгээр хангах; -Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулах, заавар, зөвлөмж боловсруулах, мэргэжил арга зүйгээр хангах; -Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөлийн асуудлыг эрхлэх, салбар зөвлөлүүдийг мэргэжил арга зүйгээр хангах.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар Аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллага, гадаадын болон олон улсын байгууллагууд
ҮЧҮ-2: Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон талт түншлэлийн харилцааг хөгжүүлэх.	-Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, шинээр байгуулах хэлэлцээрийн бэлтгэл ажлыг хангах, улс орнуудтай мэдээлэл солилцох, дамжуулах; -Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллагуудын арга хэмжээ хоорондын уялдааг хангаж, салбарын бодлоготой уялдуулах; -Улс орнуудын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах, нийгмийн даатгалын салбарын сайн туршлагыг судлах; -Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудтай холбоо тогтоох, төсөл, хөтөлбөрт хамрагдах боломжийг судлах, санал боловсруулах; -Салбарын ажилтнуудыг гадаад улсад богино болон урт хугацааны сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах.	

ҮЧҮ-3: Судалгаа, шинжилгээ хийх, нийгмийн даатгалын сангийн статистик мэдээлэл боловсруулах, хэтийн төлөв, дунд, урт хугацааны урьдчилсан тооцоолол, тэтгэврийн нөөц сангийн тооцоолол хийх;	-Нийгмийн даатгалын сангийн сар, улирлын мэдээ тайлангийн гүйцэтгэлд шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах; -Нийгмийн даатгалын үндсэн үзүүлэлтүүдийн сар, жилийн эцсийн статистик мэдээллийг бэлтгэх, холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх; -Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж, эрх бүхий байгууллагад уламжлах шийдвэрлүүлэх; -Нийгмийн даатгалын байгууллагуудыг судалгааны ажлын арга зүйгээр хангах, судалгаа хийх аргачлал, заавар, чиглэл боловсруулах; - Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын дунд болон урт хугацааны хэтийн төлөв байдлыг тооцоолоход шаардлагатай мэдээлэл цуглуулах, тэтгэврийн нөөц сангийн тооцоолол хийх, хугацааны тодорхой үечлэлээр үнэлэлт дүгнэлт өгөх, судалгаа, тооцоолол хийх; - Нийгмийн даатгалын салбарын сангийн болон үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын төсвийн гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийх, зардлын норм, норматив тогтоох, зардлын төсвийн гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлүүд, шалтгааны судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, актуар тооцоолол хийх, санал боловсруулах, шийдвэрлүүлэх.
ҮЧҮ-4: Нийгмийн даатгалын сангийн болон салбарын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсвийн төсөл, дунд хугацааны төсөөлөл боловсруулах;	-Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн хязгаарын санал, дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл, нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох хөрөнгийг актуар тооцоололд үндэслэн төлөвлөх, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих; -Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан асуудлын хүрээнд тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдсон шаардагдах хөрөнгийн тооцоо хийх; -Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, батлагдсан төсвийг нийгмийн

	даатгалын байгууллагууд, зардлын зүйлээр нарийвчлан хуваарилах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих; -Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, аргачлал, журам, заавар, чиглэл, мэргэжил арга зүйгээр хангах.	
Ерөнхий чиг үүрэг-3: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, удирдлагыг бодит, мэдээллээр хангах;	-Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар зэрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах; -Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх, үр дүнг тайлагнах; -Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах; -Нийгмийн даатгалын ерөнхий газар, зохион байгуулалтын нэгжүүд, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах; -Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээлэлд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах;	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар Төрийн бус байгууллага, төрийн аудитын байгууллагууд

	-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах; -Агентлагийн үндсэн чиг үүрэгт шууд хамаарах чиглэлээр тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах. -Төсвийн шууд захирагчийн хөрөнгийн төлөвлөлт, зүй зохистой, үр ашигтай хуваарилсан байдалд дотоод аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах; -Нийгмийн даатгалын сангийн зарлага, төсвийн зарцуулалтад аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах; -Байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн зарцуулалтад аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах.	
Ерөнхий чиг үүрэг-4: Хяналт шалгалтын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Хяналт шалгалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Салбарын хяналт шалгалтын бодлого боловсруулах, төлөвлөх, гүйцэтгэлийг удирдах;	-Нийгмийн даатгалын хууль болон холбогдох бусад хууль тогтоол, шийдвэр, бодлогын хэрэгжилтийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт шалгах ажлыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авах, мэргэжил, арга зүйгээр хангах, соён гэгээрүүлэх, дэмжлэг тусалцаа үзүүлэх, үр дүнг тооцож, тайлагнах; -Хяналт шалгалтын явцад илэрсэн төлбөр, зөрчил дутагдлыг холбогдох эрх зүйн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах; -Нийгмийн даатгалын байгууллагын дотоод хяналт, шалгалтын тайланг нэгтгэх, илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтад хяналт тавих; -Нийгмийн даатгалын албан журмаар болон сайн дураар даатгуулагчдын хамралт, шимтгэл ногдуулалт, гэрээний эрх зүйн харилцааг холбогдох баримт, цахим мэдээлэлд тулгуурлан шалгах;	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар Шүүх, Цагдаа, Прокурор, Шүүхийн шийдвэр

	-Гадаад улс орнуудад хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдыг нийгмийн даатгалд хамруулах хэлэлцээрийн хэрэгжилт, тэдгээрийн шимтгэл төлөлтийн тайлан тооцооны үндэслэлийг цахим мэдээллийн санд тулгуурлан шалгах; -Тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг, тэтгэвэр тогтооход баримталсан баримт бичгийн үндэслэлийг шалган зааварлах; -Хяналт, шалгалтаар тогтоогдсон акт, төлбөр, алданги, шийтгэлийн хуудсаар оногдуулсан торгуулийн барагдуулалтад хяналт тавьж үр дүнг тооцох; -Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг аж ахуйн нэгж, байгууллагуудад шалгах ажлыг зохион байгуулах, зөвлөмж, зөвлөгөө өгөх болон хууль тогтоомжийн хүрээнд зохих шийдвэр гаргаж үр дүнг тайлагнах, хэрэгжилтэд хяналт тавих; -Гадаад улсын иргэнд болон Монгол Улсын иргэний харьяатаас гарсан иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгосон эсэхэд хяналт тавих; -Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх чиглэлээр хийх эрсдэлийн үнэлгээг татварын мэдээллийн санд үндэслэн хийж, хяналт шалгалт хийх.	гүйцэтгэх, Шүүхийн шинжилгээний болон бусад хууль хяналтын байгууллагууд
ҮЧҮ-2: Нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих, хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийгмийн даатгалын ажилтны ёс зүйг сахиулах, ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр салбарын хэмжээнд хяналт шалгалтыг зохион байгуулах.	-Нийгмийн даатгалын хамралт, сангуудын орлого, зарлагын төлөвлөлт, тооцооны үндэслэлийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгах, дүгнэлт өгөх; -Нийгмийн даатгалын сангуудын орлогын бүрдүүлэлт, байршуулалт, хуваарилалт, зарцуулалтыг баримтаар болон цахимаар шалгах; -Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын нийгмийн даатгалын сангуудын улирал, жилийн тайлангийн үндэслэлийг анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, цахим мэдээлэлд тулгуурлан шалгах; -Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн сар, улирлын тайлан, хуримтлагдсан өр, авлагын тооцооны үндэслэлийг нягтлан бодох бүртгэл, цахим мэдээлэл, даатгуулагчийн төрөл, кодоод тулгуурлан шалгах; -Тэтгэврийн төрөл тус бүрээр холбогдох данс бүртгэл, олголтын файл, цахим мэдээлэлд тулгуурлан бүрэн буюу хэсэгчлэн, түүвэрчлэх аргаар	

	шалгах, тэтгэвэр авах эрх зүйн харилцаа дуусгавар болсон, шилжиж ирсэн, явсан, зогсоогдсон иргэдийн тэтгэврийн олголтын тооцоог цахимаар шалгах; -Тэтгэмжийн, ажилгүйдлийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгосон тэтгэмж, төлбөр, зардал, хөнгөлөлт, чөлөөлөлт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын тооцоо, гүйцэтгэлийг үндсэн баримт, цахим мэдээлэлд тулгуурлан шалгах; -Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын батлагдсан төсвийг зүйл анги, зориулалтаар нь зарцуулсан байдал, зардлын болон цалингийн сан, орон тооны гүйцэтгэлийг шалгах; -Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих; -Нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өрийг хууль тогтоомжийн дагуу барагдуулах ажлыг зохион байгуулах, санал боловсруулах, үр дүнг тооцох; -Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагын дэлгэрэнгүй судалгаа гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах; -Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулахтай холбоотой журам заавар, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах; -Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, өр авлага барагдуулах журам, зааврын хэрэгжилтийг хангах, хяналт тавих, байгууллага ажил олгогчдод өр үүссэн хугацаа, үүсэх эрсдэлээс сэргийлэх, сурталчлах.	
ҮЧҮ-3: Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих	Ерөнхий чиг үүрэг-5: Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр	
Үндсэн чиг үүрэг: Санхүү, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид

ҮЧҮ-1: Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага;	-Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг Төрийн сан болон арилжааны банкуудаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах; -Улсын төсвийн санхүүжилтийг нэхэмжилж авах; -Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгох; -Шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд ажил олгогч, даатгуулагч тус бүрээр бүртгэх.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар Банк, санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн бус байгууллагууд
ҮЧҮ-2: Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийг хангуулах;	-Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр тогтоосон хугацаанд боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; -Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын мэдээг сар бүр тогтоосон хугацаанд боловсруулж, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; -Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон сангийн төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	
ҮЧҮ-3: Тэтгэврийн нөөц сан, сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулж, нэмэгдүүлэх;	-Тэтгэврийн нөөц санг хуулиар тогтоосон хугацаанд бүрдүүлэх; -Мөнгөжүүлсэн орлогыг даатгуулагч бүрээр хуваарилж, бүртгэх ажлыг зохион байгуулах; -Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх.	
ҮЧҮ-4: Өмчийн харилцаа, хөрөнгө оруулалт;	-Нийгмийн даатгалын байгууллагын худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хангуулж, тайлагнах; -Нийгмийн даатгалын байгууллагын өмч хөрөнгийн хөдлөл, хөдөлгөөн, ашиглалтын өгөөжийг нэмэгдүүлэх; -Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягтын хэрэгцээ шаардлагыг тооцоолох, захиалах, хэвлүүлэх, хуваарилах;	

ҮЧҮ-5: Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг боловсруулан тайлагнах;	-Нийгмийн даатгалын салбарын эргэлтийн болон үндсэн хөрөнгийн тооллогын дүнг гаргах, холбогдох арга хэмжээг авах. -Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хуулиар тогтоосон хугацаанд боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэх; -Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хуулиар тогтоосон хугацаанд боловсруулан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; -Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх.
Ерөнхий чиг үүрэг-6: Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах чиглэлээр	
Үндсэн чиг үүрэг: Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, үйл ажиллагааны стандартыг сайжруулах, ажил олгогчид, даатгуулагчид, иргэд, тэтгэвэр авагчдын сэтгэл ханамжийг судлах, чанар, хүртээмжийг сайжруулах түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;	-Нийгмийн даатгалын байгууллагын ажлын байрны зохион байгуулалтад шинэ стандарт нэвтрүүлэх, хэвшүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; -Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр гадаад, дотоодын сайн туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлэх; -Нийгмийн даатгалын үйлчилгээний соёл, байцаагч, ажилтнуудын харилцаа, хандлагыг дээшлүүлж, журам, стандартыг мөрдөж ажиллах чиглэлээр санал боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих; Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид,

	-Нийгмийн даатгалын үйлчилгээнд мэдээллийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэх ажлыг зохион байгуулах; -Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, цахим төлбөр тооцооны дэвшилтэт арга хэрэгслийг нэвтрүүлэх судалгаа хийх, цахим үйлчилгээг хөгжүүлэхтэй холбогдуулан төрийн байгууллага болон банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх; -Гадаадад амьдарч буй Монгол улсын иргэдийг нийгмийн даатгалд цахимаар хамрагдах боломжийг сайжруулах; -Ажил олгогчид, даатгуулагчид, иргэд, тэтгэвэр авагчдаас цахим хэлбэрээр ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх, санал боловсруулах, залруулах үйл ажиллагааг зохион байгуулах; -Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах утасны үйл ажиллагааг сайжруулах, мэдээллээр хангах, хяналт тавих.	аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар Хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагууд
ҮЧҮ-2: Үйл ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ажил олгогчид, даатгуулагчдад хүргэх, байгууллагын нээлттэй, ил тод байдлыг хангах;	-Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагааны талаар зорилтот мэдээлэл бэлтгэж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ажил олгогч, даатгуулагчдад хүргэх, хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах; -Хэвлэл мэдээллийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэж, эх сурвалж, мэдээллээр хангах; -Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлд мониторинг хийх, салбарын үйл ажиллагаатай холбоотой ташаа мэдээлэл гарсан тохиолдолд залруулах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах; -Нийгмийн даатгалын үйл ажиллагааны талаарх үнэн бодит мэдээллийг вэб сайтаар дамжуулан даатгуулагч, олон нийтэд шуурхай хүргэж, тогтмол шинэчлэх; -Нийгмийн сүлжээний хэрэгсэл, нийгмийн даатгал аппликейшн ашиглан мэдээлэл, сурталчилгаа хийх, мэдээллийг тогтмол шинэчлэх, идэвхжүүлэх, эргэлтэд хяналт тавих;	

	-Нийгмийн даатгалын үйлчилгээг нээлттэй өдөрлөг, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах зэргээр өргөн хүрээнд сурталчилгаа явуулах; -Нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан ном, товхимол, гарын авлага, танилцуулга, зурагт хуудас бэлтгэх, хэвлүүлэх, тараах.	
Ерөнхий чиг үүрэг-7: Эрүүл мэндийн магадлалын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	-Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журам, заавар, чиглэл, зөвлөмж боловсруулж салбар болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах; -Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн хурал болон төв зөвлөлийн хамтарсан, дахин магадлалыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах; -Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээний чанар, эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэлд хяналт тавих, мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлэх, хяналт, шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; -Сэтгэцийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн хурлын үйл ажиллагаанд оролцож, хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах; -Эрүүл мэндийн магадлалын төв болон салбар, аймаг, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааны төсвийн төсөл, төсөөллийн санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлэх; -Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудасны бичилт, олголттой	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар Эрүүл мэндийн байгууллагууд болон төрийн бус байгууллагууд

	холбоотой маргааныг хянан шийдвэрлэх; -Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах; -Эрүүл мэндийн магадлалын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр улсын зөвлөгөөн, сургалт, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах; -Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, эрх зүй болон тэдгээрийн шинэчлэлийн талаар мэдээлэх сурталчлах, цаг үеийн мэдээллийг олон нийтэд түгээх, сурталчлах; -Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн сургалтын хэрэгцээг судалж, давтан сургах, сургалтад хамруулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх; -Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлөөс ирүүлсэн тооны тайланг улсын хэмжээнд хагас, бүтэн жилээр нэгтгэн дүгнэж, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	
Ерөнхий чиг үүрэг-8: Мэдээллийн технологийн чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Мэдээллийн технологи хариуцсан бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг: ҮЧҮ 1: Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай төлөвшүүлэх;	Дэд чиг үүрэг -Мэдээллийн технологийн хэрэглээний ба техник, программ хангамжийн шинэчлэл, боловсруулалт, нэвтрүүлэлт, өгөгдөл мэдээллийг цуглуулах, дамжуулах, хадгалах, хамгаалах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх; -Нийгмийн даатгалын салбарын нэгдсэн сүлжээг үүсгэж, мэдээллийн урсгалын хурдыг сайжруулах; -Нийгмийн даатгалын үйл ажиллагааг автоматжуулах, мэдээллийн технологийн суурилан өгөгдлийг цахим хэлбэрээр цуглуулах, дамжуулах, боловсруулах, хуримтлуулах, нэгтгэх, нөөцлөх, хадгалах;	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар

	-Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай хэрэглээний болон системийн, тусгай зориулалтын программ хангамж худалдан авах, боловсруулах, турших, нэвтрүүлэх. -Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, харилцагч байгууллагуудад цахимаар хүргэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх; -Нийгмийн даатгалын байгууллагуудад компьютерын локал сүлжээ суурилуулах, өргөтгөх, сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах; -Нэгдсэн мэдээллийн сангаас үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн боловсруулалт хийх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах; -Нийгмийн даатгалын байгууллагуудад ашиглагдах компьютер, техник хэрэгслийг бэлтгэн нийлүүлэх, суурилуулах, ашиглалтад оруулах, хэвийн ажиллагааг хангах, сэргээн засварлах, өргөтгөн сайжруулах.	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, ажил олгогчид
ҮЧҮ-2: Төрийн үйлчилгээг цахимжуулах замаар үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сүлжээ байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.		
Ерөнхий чиг үүрэг-9: Бүгд Найрамдах Солонгос Улсад амьдарч буй Монгол Улсын иргэдэд эрх зүйн тусалцаа үзүүлэх чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: БНСУ-д ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, эрх зүйн тусалцаа үзүүлэх бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, тэдний төлсөн шимтгэлийг бүртгэх, тайлагнах, шимтгэлийн буцаан олголтыг холбогдох журмын дагуу зохион байгуулах, сурталчлах.	-БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах иргэдтэй гэрээ байгуулж, сертификат олгох; -БНСУ-д амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг сайн дурын даатгалд хамруулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх; -БНСУ-ын үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл давхардуулан төлүүлэхгүй байх талаар лавлагаа мэдээллээр хангах; -БНСУ-ын үндэсний тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэлийг буцаан олгох; -Даатгуулагчдыг мэдээллийн санд бүртгэн тооцоо хийж, тайлан, мэдээ гаргах; -БНСУ-ын адил төстэй үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг хөгжүүлэх.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад яам, агентлаг Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба болон адил төстэй үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн даатгалын байгууллагын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, цаашдын зорилго, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд нийгмийн даатгалын салбарын статистик тоон мэдээлэл, судалгаа, төсөв, санхүүгийн тайлан болон мандатын шинжилгээнд үндэслэн SWOT шинжилгээ хийж гүйцэтгэв.

Нийгмийн даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон. Уг зорилгын нэг илрэл нь иргэдийн хөдөлмөрлөх болон түүнтэй холбогдсон нийгмийн хамгааллын эрхийн баталгааг хангах явдал юм. Энэ хүрээнд 1995 оноос иргэд, ажил олгогчид нийгмийн даатгалын шимтгэл төлж, тусгай сан бүрдүүлэн, уг сангаас аливаа эрсдэл тохиолдсон даатгуулагчдад шимтгэл төлсөн хугацаа, хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс нь хамааралтайгаар тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох агуулга бүхий нийгмийн даатгалын тогтолцоог шинээр бүрдүүлсэн.

Нийгмийн даатгалын тухай хууль 1994 онд батлагдаж, 1995 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг хуульд нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөх, нийгмийн даатгалын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг чиглэлээр нийт 31 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчлэх практик шаардлагын хүрээнд Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эрхлэн мөрдөж байна.

Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын тогтоол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал болон бусад салбарын сайдын хамтарсан тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар нийт 69 дүрэм, журам, заавар, аргачлал шинээр батлагдахаас 64 дүрэм, журам, заавар, аргачлал батлагдсан. Эдгээрээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар 11 дүрэм, журам, заавар, аргачлал батлахаас 9 дүрэм, журам, заавар, аргачлалыг батлав.

Чанарын удирдлагын тогтолцоо

Нийгмийн даатгалын байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлэх, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, үйлчилгээний тухтай орчин бүрдүүлэх, ажилтнуудын ажлын бүтээмж, хандлага, хариуцлагыг дээшлүүлэх, иргэд-даатгуулагчид, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг стандартын шаардлагад нийцүүлэн үзүүлэх зорилгоор төрийн захиргааны байгууллагуудыг манлайлан Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2008, ISO 9001:2015, MNS ISO 9001:2016 стандартыг Нийгмийн даатгалын ерөнхий газар, 14 аймаг, 5 дүүргийн Нийгмийн даатгалын газар үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын орон тооны дээд хязгаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” А/163 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагын орон тооны хязгаарыг 1477 байсныг 136 орон тоогоор бууруулж, 1341-ээр баталсан.

Энэ тушаалыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлав.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар, салбарын нэгжийн батлагдсан орон тоо

Нэр	Батлагдсан орон тоо	Тушаалын дугаар
Нийгмийн даатгалын ерөнхий газар	84	НДЕГ-ын даргын 2025 оны А/237
Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл	7	НДЕГ-ын даргын 2025 оны А/236
Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв	18	НДЕГ-ын даргын 2025 оны А/235
Аймгийн Нийгмийн даатгалын газар (21)	824	НДЕГ-ын даргын 2025 оны А/239
Дүүргийн Нийгмийн даатгалын газар (9)	399	НДЕГ-ын даргын 2025 оны А/238
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба	9	
Нийт	1341	

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжид нийгмийн даатгалын байцаагч, ажилтан ажиллаж нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байна.

Нийгмийн даатгалын сангийн төсөв, санхүү

Нийгмийн даатгалын санд 2024 онд 5,893.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 5,609.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 95.2 хувиар биелүүлсэн. Давхардсан тоогоор 784.5 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал болон бусад зардалд нийт 5,107.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын санд 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн, цэргийн алба хаагчдын тэтгэврийн, зарим иргэний тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээний зардал болон нийгмийн даатгалын сангийн алдагдалд 2025 онд улсын төсвөөс 1,175.0 тэрбум төгрөг шилжүүлсэн ба энэ нь 2020 онтой харьцуулахад 2.9 дахин нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалд 2024 оны байдлаар 61.0 мянган ажил олгогчийн 996.8 мянган даатгуулагч албан журмаар, 140.2 мянган хүн сайн дураар хамрагдсан. Нийгмийн даатгалын хамралтыг 2020 онтой харьцуулбал ажил олгогчдын тоо 23.7

хувиар, албан журмаар даатгуулагчдын тоо 20.7 хувиар тус тус өссөн бол сайн дураар даатгуулагчдын тоо 25.1 хувиар буурсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн нийт өрийн хэмжээ жил бүр нэмэгдэж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 520.5 тэрбум төгрөгт хүрсэн ба 2020 онтой харьцуулахад 2.6 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд, 2020-2024

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Ажил олгогчдын тоо	49,284	52,754	55,454	58,653	60,978
Даатгуулагчдын тоо	1,013,190	1,019,114	1,069,628	1,105,843	1,136,930
Үүнээс: Албан журмын	826,064	862,071	913,090	953,835	996,769
Сайн дурын	187,126	157,043	156,538	152,008	140,161
Нийгмийн даатгалын сангийн орлого, тэрбум.төг	1,878.2	2,732.0	3,512.5	4,271.6	5,609.7
Үүнээс: Улсын төсвийн татаас	399.4	593.9	842.8	764.4	1,175.0
Нийгмийн даатгалын сангийн зарлага, тэрбум.төг	2,451.8	2,565.6	3,415.7	4,036.2	5,107.2
Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, тэрбум төгрөг	196.6	297.1	354.0	399.5	520.5
Нийт тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо	657,217	748,261	747,380	745,175	784,545
Үүнээс: Тэтгэвэр авагчдын тоо	441,447	459,693	478,667	490,281	531,756
Тэтгэмж, төлбөр авагчдын тоо	215,770	288,568	268,713	254,894	252,789

Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан хуулиар тогтоосон санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно гэж заасан.

Дээрх заалтын хүрээнд 2024 онд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 300.0 тэрбум төгрөгийг 8.5-9.5 хувийн хүүтэй, 1-3 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаас худалдах, худалдан авах гэрээг Сангийн яамтай байгуулсан бөгөөд гэрээний хугацаанд нийт 55.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олно. Мөн 2025 онд банкны системд нөлөө бүхий арилжааны 4 банканд сангийн чөлөөт үлдэгдлээс 700.0 тэрбум төгрөгийг нэг жилийн хугацаатай, 15 хувийн хүүтэй мөнгөн хадгаламжийг байршуулсан ба хадгаламжийн гэрээний хугацаанд нийт 105.0 тэрбум төгрөгийн орлого олно.

Нийгмийн хамгааллын хэлэлцээр

Монгол Улсын Засгийн газар нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг 6 улстай байгуулсан. Үүнд:

-Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр (1981 он);

-Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын “Нийгмийн хамгааллын тухай” хэлэлцээр (2006 он);

-Монгол Улс, Бүгд Найрамдах Унгар Улсын хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр (2011 он);

-Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээр(2018 он);

-Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээр (2018 он);

-Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр (2019 он).

Цаашид Бүгд Найрамдах Казакстан Улс, Бүгд Найрамдах Австри Улсуудтай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр батлагдсанаар тухайн улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нийгмийн баталгаа хангагдах юм.

Нийгмийн даатгалын цахимжилт

Нийгмийн даатгалын үйлчилгээг олон нийтэд ил тод, шуурхай, чирэгдэлгүй хүргэх, хамралтыг нэмэгдүүлэх хүрээнд нийгмийн даатгалын 34 төрлийн үйлчилгээнээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлт, нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, шимтгэлээ төлөх, тэтгэвэр тогтоолтын хуудас зэрэг 24 үйлчилгээг цахимаар үзүүлж байна.

Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар дамжуулан 2024 онд нийгмийн даатгалын 18 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 14.2 сая удаа авсан байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр нийгмийн даатгалын нэгдсэн систем (SICOS)-ийг 2024 оноос үе шаттай нэвтрүүлсэн. Уг систем нь дэвшилтэд технологи дээр суурилсан, хоорондын уялдаа холбоог хангасан нэг төвлөрсөн систем бөгөөд орчин үеийн ORACLE өгөгдлийн санд суурилсан найдвартай, аюулгүй, бодит цагийн горимоор ажилдаг.

Нийгмийн даатгалын SICOS системийг аймаг, дүүрэгт нэвтрүүлэн нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, даатгуулагчдад үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж байна.

Тулгамдаж буй асуудал

-Тэтгэвэр авагчдын тоо жилд дунджаар 3.6 хувиар нэмэгдэж, цаашид ч өсөх хандлагатай байна. Хүн амын насжилт нэмэгдэж, Монгол Улсын хувьд 65 ба түүнээс дээш настай ахмад настны нийт хүн амын тоонд эзлэх хувь 2020 онд 4.3 хувь, 2030 онд 6.9 хувь, 2040 онд 9.5 хувь, 2050 онд гэхэд 11.9 хувь болж, хүн ам зүйн хөгшин бүтэцтэй болохоор байна.

-Хүн амын насжилтаас шалтгаалан тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээ 2030 онд ДНБ-ний 3.2 хувь буюу 3.8 их наяд төгрөг, 2050 онд ДНБ-ний 5.0 хувь буюу 18.7 их наяд төгрөг болж өсөх төлөвтэй байна.

-Зарим нийгмийн даатгалын сан орлогоороо зарлагаа нөхөж чадахгүй нөхцөл байдал үүсэж байна. Тухайлбал ажилгүйдлийн тэтгэмжийн зардал жилд дунджаар 28.8 хувиар өсөж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 136.3 тэрбум төгрөгт хүрч, ажилгүйдлийн тэтгэмжийг хугацаанд олгоход хүндрэл үүсэж байна.

-Эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын шимтгэлээ хугацаандаа төлөх хандлага буурснаар нийгмийн даатгалын шимтгэлийн өрийн хэмжээ жилд дунджаар 28.4 хувиар нэмэгдэж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 520.5 тэрбум төгрөгт хүрсэн. Ингэснээр даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмж авах нөхцөл хангагдахгүй байх хүндрэл үүсэж байна.

- Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тоо жилд дунджаар 6.8 хувиар буурч байна. Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх хүрээнд төрөөс зорилтот бүлгүүдэд чиглэсэн урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ч хамралтын хувь төдийлөн нэмэгдэхгүй байна. Тухайлбал 2024 оноос малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс хариуцан төлөх зохицуулалт хэрэгжиж байгаа бөгөөд малчдын хамралт өмнөх онтой харьцуулахад 7.2 хувиар нэмэгдэж, 2024 онд нийт 53.8 мянган малчин нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан байна.

-Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулиуд хэрэгжсэнээр тэтгэврийн даатгалын сангийн зардлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн тооцох хуулийн үйлчлэлд 607.8 мянган хүн хамрагдаж, 2023 оны байдлаар 37.9 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлсэн бөгөөд уг хуулийн үйлчлэлд хамрагдсан 344.4 мянган хүн тэтгэврээ шинээр болон өөрчлөн тогтоолгож, тэтгэврийн зардалд нэмж 1.9 их наяд төгрөг зарцуулсан байна. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн үйлчлэлд 34.4 мянган хүн хамрагдаж, 76.4 тэрбум төгрөгийн шимтгэл төлсөн ба үүнээс 23.2 мянган хүн тэтгэвэр тогтоолгож, тэтгэврийн зардалд 298.7 тэрбум төгрөг зарцуулсан дүнтэй байна.

Хүснэгт 6. SWOT шинжилгээ

ДОТООД ОРЧИН	
ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
-Хууль эрх зүйн тогтолцоо бүрдсэн: Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсан. -Нэгдсэн систем хөгжиж байгаа: Нийгмийн даатгалын нэгдсэн систем (SICOS)-ийг нэвтрүүлэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж байна. -Бүх аймаг, сум, дүүрэгт нийгмийн даатгалын байцаагч, ажилтантай: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжид газар, нийгмийн даатгалын байцаагч, ажилтан, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлдэг.	-Нийгмийн даатгалын хамралт бага: Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарын ажилчид, гадаадад ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн нийгмийн даатгалын хамралт бага байна. -Санхүүгийн эрсдэлтэй нөхцөл байдал: Тэтгэврийн санд улсын төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээ, ажилгүйдлийн даатгалын сангийн зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийн хэмжээ жил бүр нэмэгдсээр байна.
ГАДААД ОРЧИН	
БОЛОМЖ	ЭРСДЭЛ
-Цахим үйлчилгээг өргөжүүлэх: Төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia, SICOS системээр дамжуулан нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах.	-Хүн амын насжилт: Тэтгэвэр авагчдын тоо нэмэгдэж, шимтгэл төлөгчдийн тоо буурах эрсдэл үүсэх.

-Олон улсын туршлага нэвтрүүлэх: Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх. -Хамралтыг нэмэгдүүлэх: Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарын ажилчид, гадаадад ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэд болон зорилтот бүлэгт нийцүүлэн бодлогын шинэ хувилбаруудыг хэрэгжүүлэх.	-Эдийн засгийн тогтворгүй байдал: Инфляц, ажилгүйдлийн түвшин нэмэгдэх, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт буурах эрсдэл үүсэх. Ажилгүйдлийн даатгалын сан алдагдалд орох эрсдэлтэй. -Хууль зөрчсөн үйлдлүүд: Шимтгэл төлөхөөс зайлсхийх, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зэрэг хууль зөрчсөн үйлдлээс санд хохирол учруулах эрсдэлтэй.
--	---

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО


Стратегийн зорилго

Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт

1. Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлнэ.
2. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
3. Нийгмийн даатгалын сангийн орлогын бааз суурийг нэмэгдүүлнэ.

ДОЛОО. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



Төсвийн Ерөнхийлөн захирагч


.....
(гарын үсэг)

/ Т.АУБАКИР /

(огноо)

.....

Төлөвлөгөө боловсруулсан:



Төсвийн Шууд захирагч


.....
(гарын үсэг)

/ Б.БАТЖАРГАЛ /

(огноо)

.....

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин				Эх үүсвэр
				2025	2026	2027	2028	
Ерөнхий чиг үүрэг: Нийгмийн даатгал								
Үндсэн чиг үүрэг: Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд даатгуулагч, ажил олгогчид олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг								
Зорилт 1. Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлнэ.	1.1. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд холбогдох санал хүргүүлэх.	Хүргүүлсэн саналын тоо	4	1	-	-	-	Улсын төсөв
	1.2. Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд санал хүргүүлэх.	Хүргүүлсэн саналын тоо	-	4	-	-	-	Улсын төсөв
	1.3. Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, дүрэм, заавар, аргачлалыг боловсруулж батлуулах.	Батлагдсан журам, дүрэм, заавар, аргачлалын тоо	9	2	-	-	-	Улсын төсөв
Зорилт 2. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2.1. Засгийн газар хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинээр байгуулахад хамтран ажиллах.	Хамтран ажилласан нийгмийн хамгааллын хэлэлцээрийн тоо, өссөн дүнгээр	6	-	7	8	9	Улсын төсөв, бусад эх үүсвэр
	2.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцын	Тэтгэврийн нэмэгдлийн хувь	100.0 мян.төгрөгөөр нэмэгдүүлж,	6	8.6	6.5	6.5	Улсын төсөв

Стратеги зорилт 3. Нийгмийн даатгалын сангийн орлогын суурийг нэмэгдүүлнэ.	түвшинтэй нэмэгдүүлэх.	уялдуулан		бүрэн тэтгэвэр 650.0, хувь тэнцүүлсэн тэтгэвэр 540.0 мян.төг						
	2.3. Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах.	Цахимжуулсан үйлчилгээний тоо, өссөн дүнгээр	24	26	27	28	29	Улсын төсөв, бусад эх үүсвэр		
	2.4. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг сайжруулах.	Иргэд, даатгуулагчдын сэтгэл ханамжийн түвшин	-	4.2	4.3	4.4	4.5	Улсын төсөв		
	3.1. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид болон нийгмийн даатгалын харилцаанд оролцогч бусад талуудын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх замаар нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх.	Ажиллах хүчэнд даатгуулагчдын эзлэх хувь	80.9	81.1	82.7	84.2	85.4	Улсын төсөв, бусад эх үүсвэр		
3.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өрийг бууруулах.		Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өрийн хэмжээг бууруулсан хувь	-	10	10	10	10	Улсын төсөв		
		Арилжааны банканд байршуулсан	-	15	15	15	15	Улсын төсөв		

	менежментийг сайжруулах, ил тод, шилэн болгох.	хөрөнгийн өгөөжийн хувь							
		Засгийн газрын бондын өгөөжийн хувь	8.5	9	9	9	9	9	Улсын төсөв
		Цахим хуудаст байршуулсан мэдээллийн тоо	-	12	12	12	12	12	Улсын төсөв
	3.4. Эрсдэлд суурилсан цахим хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлэх.	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	1	2	2	2	2	Улсын төсөв

---oO---

НАЙМ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН ЗУРАГЛАЛ

